


НИЙГМИЙН ХӨГЖИЛД НИЙСЛЭЛ ХОТЫН ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

Монгол улсын нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын 45.0 хувь буюу бараг 2 хүн тутмын нэг нь нийслэл хотод оршин сууж байна. Нийслэлийн хүн амын 94.9 хувь нь төвийн 6 дүүрэгтээ, тодруулбал зүүн хэсэгт орших Баянзүрх дүүрэгт 23.9 хувь, баруун хэсэг Сонгинохайрхан дүүрэгт 22.8 хувь, хотын төв Баянгол дүүрэгт 15.3 хувь, баруун хойт хэсгийн Чингэлтэй дүүрэгт 11.5 хувь, баруун өмнөд хэсэгт орших Хан-Уул дүүрэгт 11.2 хувь, зүүн хойт хэсгийн Сүхбаатар дүүрэгт 10.2 хувь, үлдсэн 5.1 хувь нь Налайх, Багануур, Багахангай дүүрэгт тус тус амьдарч байна.

Зураг 1. Монгол улсын хүн ам, бүсээр



Зураг 2. Хүн амын тархалт, дүүргээр




2000 онд нийслэлийн нэг км² нутаг дэвсгэрт 162 хүн оршин сууж байсан бол 2001 онд 168 хүн, 2002 онд 175 хүн, 2003 онд 185 хүн, 2004 онд 195 хүн, 2005 онд 202 хүн, 2006 онд 210 хүн, 2007 онд 218 хүн, 2008 онд 227 хүн, 2009 онд 235 хүн, 2010 онд 247 хүн, 2011 онд 252 хүн, 2012 онд 259 хүн, 2013 онд 269 хүн, 2014 онд 279 хүн, 2015 онд 286 хүн оршин суух болжээ. Улаанбаатар хотын хүн амын нягтрал 2012-2015 оны хооронд 10.4 хувиар өсчээ.

Хүснэгт 1. Суурин хүн амын тоо, хүн амын нягтрал, дүүргээр

Дүүрэг	Нутаг дэвсгэр /км ² /	Хүн амын тоо /мян.хүн/				Хүн амын нягтрал, нэг км ² -д			
		2012 он	2013 он	2014 он	2015 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
Нийслэлийн дүн	4704.4	1227.0	1267.0	1314.5	1345.5	259	269	279	286
Баянзүрх	1244.1	294.9	304.3	308.7	320.9	232	245	248	258
Сонгино хайрхан	1200.6	261.9	277.3	295.8	307.2	216	231	246	256
Баянгол	29.5	192.6	200.2	208.9	205.7	6521	6785	7081	6975
Чингэлтэй	89.3	153.9	155.9	159.5	154.8	1719	1745	1786	1733
Хан-Уул	484.7	127.5	131.1	138.4	151.0	255	270	285	312
Сүхбаатар	208.4	132.1	133.3	136.4	137.6	648	640	655	660
Налайх	687.6	32.9	33.2	34.6	35.8	48	48	50	52
Багануур	620.2	27.5	27.9	28.3	28.4	44	45	46	46
Багахангай	140.0	3.7	3.8	3.9	4.1	26	27	28	29

Хүн амын нягтрал Баянгол /6975/, Чингэлтэй /1733/, Сүхбаатар /660/ дүүрэгт хамгийн их буюу нийслэлийн дунджаас 2.3-24.3 дахин их байна. Харин захын 3 дүүрэг Налайх /52/, Багануур /46/, Багахангай /29/-д хүн амын нягтрал хамгийн бага байгаа юм.

Зураг 3. Хотуудын хүн амын эзлэх хувь



Улаанбаатар хот Монгол улсын нутаг дэвсгэрийн дөнгөж 0.3 хувийг эзэлж, хүн амын нягтралаар хамгийн өндөр хот хэвээр байна.

Монгол улсын нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын 66.4 хувь буюу 2033.2 мянга нь хотын хүн ам буюу аймгийн төв, нийслэл, тосгоны хүн ам юм. Хотуудын хүн амын 66.2 хувь буюу гуравны хоёр хувь нь нийслэл Улаанбаатар хотод оршин сууж байна.

Нэг км² газарт ногдох хүний тоо буюу хүн амын нягтрал нийслэл хотод 286 хүн байгаа нь Монгол улсын

томоохон суурин газар болох Орхон /нягтрал 117/, Дархан-Уул /нягтрал 30/ аймгаас даруй 2.4-9.5 дахин их нягтралтай байна.

Хүснэгт 2. Нийслэлийн хороод, хүн амын тоогоор

Бүлгийн интервал	Бүлэгт хамаарах хорооны тоо	Бүлгийн хүн амын тоо	Дүнд эзлэх хувь
600-5000	24	87822	6.5
5001-6500	23	133513	9.9
6501-8000	25	180184	13.4
8001-10000	31	277033	20.6
10001-12000	20	221481	16.5
12001-15000	17	233367	17.3
15001+	12	212100	15.8

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2010 оны 6/48 дугаар тогтоолоор иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай хүргэх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор өрх, хүн амын тоо, газар нутгийн хэмжээг харгалзан 2011 оноос 20 хороо шинээр байгуулж нийтдээ 152 хороотой болсон. Шинээр 20 хороо нэмж байгуулахдаа хуучин үйл ажиллагаа явуулж байсан 132 хорооны 28 хорооноос өрх, хүн амын тоо, газар нутгийг салган өөрчлөлт оруулснаас гадна 4 хорооны өрх, хүн амын тоо, газар нутгийн хэмжээнд зохицуулалт хийсэн.

Нийслэл хот засаг захиргааны анхан шатны 152 нэгжтэй болсноор нэг хороонд дунджаар 8852 хүн оршин сууж байгаа нь нийслэлээс бусад аймгуудын нэг сумын дундаж хүн амын тооноос 1.8 дахин илүү байна.

Нэг хороонд оршин суух дундаж хүн амын тоо 8852 болж өмнөх оноос 204 хүнээр илүү болжээ. Нэг хороонд оршин суудаг хүн амын тоогоор Сонгинохайрхан, Баянгол, Баянзүрх дүүргүүд тэргүүлж байна. Нийслэл хотын хамгийн их хүн амтай Баянзүрх дүүргийн 5-р хороонд 20959 хүн, харин хамгийн бага хүн амтай Багануур дүүргийн 2-р хороонд 644 хүн оршин суудаг.

2015 онд Улаанбаатар хотод 41447 эхээс, 42790 хүүхэд төрж, 7245 хүн нас барж, ердийн цэвэр өсөлтөөр 35545 хүнээр нэмэгдсэн байна. Цэвэр өсөлтөд нийслэл хотын эзлэх хувийн жин 2010 оны байдлаар 43.9 хувьтай байсан бол жил ирэх тусам нэмэгдсээр 55.1 хувьтай болоод байна.

Хүснэгт 3. Хүн амын цэвэр өсөлт

		2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
Улаанбаа тар	Төрсөн хүүхдийн тоо	26828	30226	33324	36421	37672	42790
	Нас барсан хүний тоо	7064	7768	7554	7068	7608	7245
	Хүн амын цэвэр өсөлт	19764	22458	25770	29353	30064	35545
Улсын дүн	Төрсөн хүүхдийн тоо	63270	69853	73839	79780	82839	82130
	Нас барсан хүний тоо	18293	19155	17761	17247	16521	17620
	Хүн амын цэвэр өсөлт	44977	50698	56078	62533	66318	64510
Цэвэр өсөлтөд нийслэл хотын эзлэх хувийн жин		43.9	44.3	46.0	46.9	45.3	55.1


Төрөлтийн ерөнхий коэффициент буюу 1000 хүн амд ногдох төрөлт 31.0 болж 2010 оноос 9.0 промилээр өсч, харин нас баралтын ерөнхий коэффициент буюу 1000 хүн амд ногдох нас баралт 5.3 болж 2010 оноос 0.5 промилээр буурчээ.

Хүснэгт 4. Төрсөн хүүхдийн тоо, дүүргээр, 2009-2015 он

Дүүрэг	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
Багануур	631	657	753	850	762	803
Багахангай	91	98	103	106	109	177
Баянгол	3803	4452	5002	5543	5803	7269
Баянзүрх	6134	6941	7530	8310	8404	9961
Налайх	796	881	874	968	947	1059
Сонгинохайрхан	6155	6883	7502	8171	8688	9636
Сүхбаатар	2967	3242	3430	3914	3889	4213
Хан-Уул	2657	3112	3471	3999	4450	4921
Чингэлтэй	3594	3960	4659	4560	4620	4751
Нийслэлийн дүн	26828	30226	33324	36421	37672	42790
Улсын дүн	63270	69853	73839	79780	82839	82130
Улсын дүнд эзлэх хувь	42.4	43.3	45.1	45.7	45.5	52.1

Улаанбаатар хотод 2015 онд 42790 хүүхэд мэндэлсэн нь 2010 оноос 15962 хүүхдээр буюу 59.5 хувиар илүү байна. Нийт төрсөн хүүхдийн 4.1 хувь буюу 1748 нь 19 хүртэл насны эхээс, 23.3 хувь буюу 9985 нь 20-24 насны эхээс, 32.8 хувь буюу 14027 нь 25-29 насны эхээс, 23.4 хувь буюу 10018 нь 30-34 насны эхээс, 13.1 хувь буюу 5595 нь 35-39 насны эхээс, 3.2 хувь буюу 1368 нь 40-44 насны эхээс, 0.1 хувь буюу 49 нь 45-аас дээш насны эхээс тус тус мэндэлжээ. 20-24 насны 1000 эмэгтэй тутмаас 174 хүүхэд, 25-29 насны 1000 эмэгтэй тутмаас 179 хүүхэд, 30-34 насны 1000 эмэгтэй тутмаас 157 хүүхэд, 35-39 насны 1000 эмэгтэй тутмаас 104 хүүхэд төрсөн байна.

Зураг 4. Хүүхэд төрүүлсэн эхчүүд, боловсролын төвшнөөр



2015 онд хүүхэд төрүүлсэн эхчүүдийг боловсролын төвшнөөр нь авч үзвэл 59.4 хувь буюу 24629 нь дээд болон түүнээс дээш, 37.1 хувь буюу 15381 нь бүрэн дунд, 1.4 хувь буюу 578 нь суурь, 1.6 хувь буюу 664 нь тусгай мэргэжлийн дунд болон техникийн мэргэжлийн, 0.2 хувь буюу 80 нь бага боловсролтой, үлдсэн 0.3 хувь буюу 115 нь ямар нэг боловсролгүй, эмэгтэйчүүд байна.

Хүүхэд төрүүлсэн эхчүүдийн 10.8 хувь буюу 4486 нь гэр бүлгүй, 89.2 хувь буюу 36961 нь гэр бүлтэй хүмүүс байна.

ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Нийслэл хотын иргэдэд 2015 оны байдлаар эрүүл мэндийн салбарын үйлчилгээг 1703 байгууллагын нийт 25.0 мянган мэргэжилтнүүд үзүүлж байна. Тухайлбал 5834 их эмч, 1025 эм зүйч зэрэг 10713 дээд мэргэжлийн, 276 бага эмч, 501 лаборант, 381 гэрлийн техникч, 769 эм найруулагч, 5898 сувилагч, 269 эх баригч зэрэг 8362 дунд мэргэжлийн, бусад мэргэжлийн 5919 ажилчид ажиллаж, ард иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж байна.

Хүснэгт 5. Эрүүл мэндийн байгууллагын тоо


	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
Төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв	16	16	16	16	13	13
Дүүргийн нэгдсэн эмнэлэг	12	12	12	12	12	12
Амаржих газар	3	3	3	3	3	3
Өрхийн эмнэлэг	123	124	131	136	134	134
Хувийн эмнэлэг	848	860	675	631	751	778
Рашаан сувилал	2	48	66	45	73	89
Эмийн сан	360	374	477	373	469	461

Улсын хэмжээнд эрүүл мэндийн байгууллагад ажиллагсдын 52.4 хувь буюу 25.0 мянган хүн Улаанбаатар хотын эрүүл мэндийн байгууллагуудад ажиллаж байна. Мөн их эмч нарын 61.0 хувь, эм зүйч нарын 68.2 хувь, эмнэлгийн дунд мэргэжлийн ажилтны 44.5 хувь нь тус тус нийслэл хотод ажиллаж байна.

Хүснэгт 6. Эрүүл мэндийн байгууллагын ажиллагчдын тоо

Мэргэжил	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
Бүгд	19383	20644	22399	23160	23923	24994
үүнээс: эмэгтэй	16361	17393	18510	18868	19724	20594
Их эмч: Бүгд	4565	4907	5359	5510	5793	5834
үүнээс: эмэгтэй	3638	3919	4217	4277	4709	4615
Дотрын	469	541	544	569	708	658
Мэс заслын ба гэмтлийн	324	352	384	398	421	428
Эх барих эмэгтэйчүүдийн	353	373	406	418	419	451
Хүүхдийн	264	284	321	318	317	337
Халдвартын	169	187	147	146	125	182
Хавдар судлалын	46	44	43	43	36	31
Нүдний	94	90	85	104	97	97
Чих, хамар, хоолойн	85	75	95	89	86	86
Сүрьеэгийн	56	57	60	57	60	48
Арьсны	88	82	85	95	97	92
Рентгений	203	218	237	263	290	320
Мэдрэл, сэтгэл мэдрэлийн	245	273	280	272	301	287
Физик эмчилгээний	65	77	87	106	95	92
Стоматологийн	387	483	561	538	701	760
Лабораторын	195	205	232	239	228	219
Бусад мэргэжлийн	1522	1566	1792	1855	1812	1746
Эм зүйчид	925	1004	1153	1248	1208	1025

Зураг 5. Нэг их эмчид ногдох хүний тоо, аймаг, нийслэлээр



2015 оны байдлаар нэг их эмчид 228 хүн, нэг сувилагчид 225 хүн ногдож байгаа нь бусад бүс нутаг, аймгуудаас ажлын ачаалал нь харьцангуй бага байна.

Хүснэгт 7. Эмнэлгийн дунд мэргэжилтний тоо

Мэргэжил	2008 он	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
Бүгд	6868	6799	6604	7063	7563	7826	8075	8362
Бага эмч	293	294	293	305	237	231	267	276
Эм найруулагч	1089	1114	1117	1171	1291	1396	829	769
Лаборант	377	375	385	412	431	451	466	501
Сувилагч	4211	4240	4396	4671	5003	5056	5598	5898
Рентгений техникч	106	99	99	98	114	129	336	381

2015 онд улсын хэмжээнд 787.8 мянган хүн хэвтэж эмчлүүлсний 53.0 хувь буюу 417.6 мянган хүн Улаанбаатар хотын эмнэлгүүдэд хэвтэн эмчлүүлжээ. Эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн хүмүүсийн 28.0 хувь нь дотрын, 8.2 хувь нь мэс заслын, 16.1 хувь нь төрөх, 3.6 хувь нь эмэгтэйчүүдийн, 11.2 хувь нь хүүхдийн тасгаар эмчлүүлсэн байна.

Хүснэгт 8. Эрүүл мэндийн салбарын зарим үзүүлэлтүүд

	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
Их эмчийн тоо	4565	4907	5359	5510	5793	5834
1 их эмчид ногдох хүний тоо	267	240	227	229	224	228
Эмнэлгийн орны тоо	8187	9044	9456	9685	10614	11485
1 оронд ногдох хүний тоо	138	131	129	129	122	116
Хэвтэж эмчлүүлсэн өвчтний тоо	314717	333326	355218	370873	394989	417631
Нялхсын эндэгдэл	487	450	486	546	625	613
Эхийн эндэгдэл	14	15	16	21	15	12
Үр хөндөлт	8214	12338	13895	10385	11900	13164

Зураг 6. Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд



Нийслэл хотод 2015 онд нэг хүртэл насны хүүхдийн эндэгдэл 613, эхийн эндэгдэл 12 гарчээ. Амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас нэг хүртэл насандаа эндсэн хүүхдийн тоо 14.3 болж өмнөх оноос 2.3 промилээр буурч, харин 2010 оноос 3.9 промилээр буурчээ.

2015 оны байдлаар эхийн эндэгдлийн 57.1 хувь, нэг хүртэл насандаа эндсэн хүүхдийн 49.7 хувь, халдварт өвчнөөр өвчилсөн тохиолдлын 68.1 хувь нь нийслэл Улаанбаатар хотод гарсан байна.

2015 онд халдварт өвчнөөр өвчилсөн 40461 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оноос 2.2 дахин их буюу 21808 тохиолдлоор, 2010 оноос 1.9 дахин их буюу 19037 тохиолдлоор тус тус нэмэгдсэн байна. Халдварт өвчний гаралт өмнөх онуудтай харьцуулахад эрс нэмэгдсэн бөгөөд 19427 тохиолдол буюу 48.0 хувийг улаан бурхан өвчний тохиолдол дангаараа эзэлж байна.

Хүснэгт 9. Бүртгэгдсэн халдварт өвчин

	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
Халдварт өвчнөөр өвчилсөн бүх хүн, үүнээс:	21424	19955	25128	18739	18653	40461
Вируст хепатит	2630	4768	2718	1207	603	523
Менингит	11	9	14	17	5	6
Цусан суулга	2797	1707	1726	1573	1921	2336
Салхин цэцэг	739	1740	1578	2552	2305	3329
Гахайн хавдар	169	477	6968	1487	188	159
Сальмонеллэз	108	77	78	49	72	105
Улаан эсэргэнэ	20	57	88	259	270	674
Хоолны хордлого	329	147	633	121	235	376
Ёлом	125	123	145	109	104	104
Улаанууд	8	15	204	9	1	26
Бруцеллэз	165	63	34	14	17	17
Гар хөл амны өвчин	1382	700	377	1262	1614	1205
Улаан бурхан	-	-	-	-	-	19427
Тэмбүү	2229	2378	2764	3269	3618	4154
Заг хүйтэн	2272	1976	2219	1767	1650	2122
Трихомониаз	1820	1683	2030	1850	1723	1950
Шинээр илэрсэн сүрьеэ	2341	2283	2261	2401	2544	2537
ХДХВ/ДОХ	21	17	27	23	31	18
Улсын хэмжээнд бүртгэгдсэн халдварт өвчин	41373	42839	43305	37318	33516	59400
Улсын хэмжээнд эзлэх хувь	51.8	46.6	58.0	50.2	55.7	68.1

Зураг 7. Халдварт өвчнөөр өвчлөгсөд



10000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо өмнөх оноос 159.7 продици-милээр, 2010 оноос 115.3 продици-милээр тус тус өсчээ. Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 48.0 хувийг улаан бурхан, 10.3 хувийг тэмбүү, 8.2 хувийг салхинцэцэг, 6.3 хувийг шинээр илэрсэн сүрьеэ, 5.8 хувийг цусан суулга, 5.2 хувийг заг хүйтэн, 4.8 хувийг трихомониаз өвчнөөр өвчлөгсөд тус тус эзэлж байна.